



Монголын Радиогоос тодруулдаг “Алтан унага”-ны эзнээр 3-р багийн малчин Д.Цэнгэл тодорч Сайхан сумаас дараалан 3 жил Алтан унаганы эзэн тодорсон түүхэн амжилт боллоо.



Энэхүү шагналын МҮОНРТелевизийн захирал Оюундарь, Аймгийн ИТХ-ын дарга Д.Батсайхан, Сумын Засаг дарга Н.Мэнд-Амар, ИТХ-ын дарга А.Бадамсүрэн нар болон бусад удирдлагууд очиж шагналыг гардууллаа.



Мөн ахмад настан, сумын сайн малчин, Сумын аварга малчин, Сумын алдарт уяач зэрэг хүмүүсийн шагналуудыг гардууллаа. Энэ долоо хоног шагналын хур буусан сайхан өдрүүд болж өнгөрлөө.

Монгол “Улсын сайн малчин” болсон “Мануулт” багийн иргэн Жадамба овогтой Дамдинсүрэнд сар шинийн өмнөх битүүний өдөр Хөдөө аж ахуйн сайд Бурмаа болон албаны бусад хүмүүс, аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбат, Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын дарга Д.Амгалан, Сайхан сумын Засаг дарга Н.Мэнд-Амар, ИТХ-ын дарга А.Бадамсүрэн, орлогч дарга Ч.Дэмбэрэлдорж нар болон албаны бусад хүмүүс шагналыг гардуулан баяр хүргэв.



Модон хонь жилийн босгон дээр сар шинийн баярын өмнө ЗДТГазрын Санхүүгийн албаны дарга Дагва овогтой Бямбаа 30 гаруй жил төрд ажилласнаа үнэлүүлж “Алтан гадас” одонгоор энгэрээ мялаалаа. Шагналыг Аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбат, сумын Засаг дарга Н.Мэнд-Амар, ИТХ-ын дарга А.Бадамсүрэн нар гардууллаа.



Манай сумаас “Чанар-Цагаан сар” үзэсгэлэн яармагт Хөдөлмөрийн мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг амжилттай оролцоод ирлээ.

1тн 300л айраг, 6 ууц, 6 ямааны гулууз мах зах зээлд борлууллаа. 1-р багийн малчин Э.Батсайхан 800л айраг, 1-р багийн малчин Б.Батсүрэн 200л айраг, 6 ууц, 6 ямааны мах, 6-р багийн малчин Ч.Дэмбэрэл 300л айраг зах зээлд борлууллаа. 1л айраг 2500т, 1 ууц 190,000 төгрөг, ямааны гулууз мах 90,000 төгрөгөөр тус тус худалдааллаа.



Өнгөрсөн жил манай сумын хувьд амжилт ололт дүүрэн сайхан жил болж өнгөрлөө

Reabody Energy компани нөхөн сэргээлт хийсэн талбайгаа хүлээлгэн өгч Хаман боогч машины ашиглах хамтран ажиллах гэрээг манай байгууллагатай хийлээ.



Засаг даргын тамгын газрын дотоод үйл ажиллагаа хэвийн явагдаж, хугацаатай мэдээ тайлан, хугацаатай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТЗАХМ Н.ЮМЧИНРАГЧАА